


**БАТЛАВ.  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**С.БЯМБАЦОГТ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Улсын Их Хурлын үйл ажиллагааг зохицуулж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталж, дагаж мөрдөж байна.

Улсын Их Хурлын үйл ажиллагааг зохицуулж буй Улсын Их Хурлын хуралдааны дэгийн гол үүрэг, мөн чанар нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй байлгах, хуралдаанаар хэлэлцүүлж байгаа асуудлыг хугацаанд нь шийдвэрлэх, асуудлыг шийдвэрлэхдээ уян хатан, ажил хэрэгч байж, шударга зарчмаар шийдвэрлэх явдал юм. Шинэчилэн батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хэрэглэх явцад зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох, нарийвчлах дараах практик хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль батлах ирцийн босгыг тогтоосонтой холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг үр нөлөөтэй явуулах, хуралдаан эхлэхэд бэлтгэл хангагдсан байх, зарим нэн яаралтай, шаардлагатай асуудалтай гишүүдийг танилцах боломжоор хангах хэрэгцээ байгаа нь шинэчлэн баталсан дэгийг хэрэглэх явцад тодорхой болсон;

2.Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор хууль санаачлагчаас ээлжит чуулганаар хэлэлцэх асуудалд ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг тухайн ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэн шийдвэрлэхээр зохицуулсан бөгөөд хууль тогтоох үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгыг хууль санаачлагчийн хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахгүй байдлаар боловсронгуй болгох шаардлага тулгарсан;

3.Түүнчлэн Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт, дараалал, цаглаварыг тодорхой болгож, Улсын Их Хурлын тогтоолоор батлах хэлэлцэх асуудлын жагсаалтад хууль санаачлагчаас саналаа ирүүлэх хугацаа заах, тогтоолд багтсан хууль, тогтоолын төслийн дараалал тогтоосон Улсын Их Хурлын даргын захирамжийн дагуу холбогдох Байнгын хороод хэлэлцэх асуудлын цаглавараа өөрсдөө батлах нь оновчтой болох нь харагдсан;

4.Шинэчлэн баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн нэг дэвшилтэт зохицуулалт нь хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагын асуудал бөгөөд хариуцлагын төрөл, хугацаа, зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэсэн хариуцлага нь аль хуралдаанд хамаарах зэрэг

зохицуулалтыг илүү тодорхой, боловсронгуй болгох хэрэгцээ байгаа нь хууль хэрэглэх явцад тодорхой болсон;

5.Тусгайлсан дэгээр зохицуулж буй зарим тогтоолын төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийн дэгийг тодорхой болгох;

6.Байнгын хороо хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг илүү ажил хэрэгч, үр дүнтэй зохион байгуулах, мэтгэлцэх зарчмыг хангахад чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байгаа;

7.Шаардлагатай тохиолдолд Ерөнхий сайдын мэдээллийг түүний томилсон Засгийн газрын гишүүн хийх боломжийг олгох зохицуулалт шаардлагатай болсон;

8.Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан маргаантай асуудлаар Үндсэн хуульд нийцсэн гэсэн дүгнэлт гаргасан бол Цэцийн гишүүн дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд шууд танилцуулах бөгөөд Улсын Их Хурал санал хурааж, шийдвэр гаргахгүй тул гишүүдийн асуултад дүгнэлттэй холбогдуулан цэцийн гишүүн хариулт өгөхгүй тул үүнтэй холбоотой дэгийг тодруулан зохицуулах шаардлагатай болсон.

Дээр дурдсан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

1.Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг үр нөлөөтэй явуулах, хуралдаан цагтаа эхлэхэд гишүүдийн бэлтгэл бүрэн хангагдсан байх үүднээс нэгдсэн хуралдааны ирцэд бүртгүүлэх цагийг 9.00 цагаас эхлүүлж 10 цагаас нэгдсэн хуралдааныг эхлүүлж байх;

2.Хууль санаачлагч, дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах саналаа тухайн ээлжит чуулган дуусахаас ажлын 10 хоногийн өмнө Төрийн байгуулалтын байнгын хороонд саналаа хүргүүлэх, ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга сар бүр захирамжаар баталж, тус захирамжийг үндэслэн холбогдох Байнгын хороод цаглавараа баталж, мөрдөх;

3.Хуралдааны дэг зөрчсөн гишүүн тухайн асуудлын хэлэлцүүлэг дуустал хуралдаан даргалагчийн шаардлагаар танхимыг орхин гарахыг хариуцлагын нэг төрөл болгох, үргэлжлүүлэн зөрчил гаргавал тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасах үндэслэл болох, түүнчлэн хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүн Улсын Их Хурлын болон гишүүний нэр хүндийг гутаан доромжилсон, эмх

замбараагүй байдал үүсгэсэн болон бусад хэлбэрээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулбал хуралдаанд оролцох эрхийг нь 3 хүртэл удаа хасахаар зохицуулж, хариуцлагын хугацааг тодорхой болгох, зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэсэн хариуцлага нь зөвхөн тухайн Байнгын, дэд, түр хорооны болон нэгдсэн хуралдаанд хамаарахаар тогтоох;

4.Тусгайлсан дэгээр зохицуулж буй зарим тогтоолын төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг хуулийн төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг явуулах дэгтэй ижил зохицуулах, түүнчлэн Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн явцад гишүүн өөрийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа татан авах боломжтой байхаар зохицуулах;

5. Байнгын хороо хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг илүү ажил хэрэгч, үр дүнтэй зохион байгуулах, мэтгэлцэх зарчмыг хангах зорилгоор Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн нээлттэй болон хаалттай явуулах;

6.Шаардлагатай тохиолдолд Ерөнхий сайдын мэдээллийг түүний томилсон Засгийн газрын гишүүн хийхээр зохицуулах;

7.Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар санал хурааж, дүнг танилцуулснаар холбогдох тогтоолын төслийг баталсанд тооцох;

8.Үндсэн хуульд нийцсэн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асуух, үг хэлэхгүй байхаар зохицуулах.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуралдааны дэгийг сахих, хэлэлцүүлгийг үр дүнтэй, шинжлэх ухааны үндэс, баримт нотолгоонд үндэслэсэн мэтгэлцээнд тулгуурлан явуулах, хуралдааны дэгийн талаар практикт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой болно.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцэх бөгөөд харшлахгүй болно.

---o0o---